



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 18 өдөр


Дугаар А/515

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн Гавьяаны Улаан Тугийн одонт Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар анги үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой энэ онд тохиож, ойн арга хэмжээ 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдөр болох тул тус ангийн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд нийт 2,949,990 төгрөгийг хавсралтын дагуу гаргаж зарцуулсугай.
2. Тус арга хэмжээнд шаардагдах 2,949,990 төгрөг (хоёр сая есөн зуун дөчин есөн мянга есөн зуу ер)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.
3. Зарцуулсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаж тайлагнахыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч хурандаа (Х.Энхболд) -д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2592
Zah A/515 tum

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 12-ны өдрийн
А/515 дугаар захирагчийн зардалт



**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 123 ДУГААР АНГИЙН 100 ЖИЛИЙН ОЙН
АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

д/д	Материалын нэр	Тоо нэгж	Мөнгөн дүн	Тайлбар
1	Мотоцикль	1	2,949,990	
	Нийт дүн	1	2,949,990	

-oOo-